

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ У.ДАВААЖАВ ТАНАА

2021.02.25 № 07/487

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам 64 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч, материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70 439 164,20	64 577 931,20
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	70 439 164,20	64 577 931,20
351	Түүхий эд материал	52 274 022,20	48 357 714,20
35110	Тусгай зориулалттай материал	52 274 022,20	48 357 714,20
354	Хангамжийн материал	18 165 142,00	16 220 217,00
35410	Бичиг хэргийн материал	855 317,00	761 349,00
35420	Аж ахуйн материал	141 857,00	216 700,00
35440	Түлш шатах тослох материал	-	69 000,00
35450	Барилгын засварын материал	1 931 100,00	1 701 300,00
35470	Бусад хангамжийн материал	15 236 868,00	13 471 868,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3 133 855 522,21	5 511 797 850,01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3 133 855 522,21	5 511 797 850,01
392	Биет хөрөнгө	3 133 810 522,21	5 510 887 850,01
39201	Барилга, байгууламж	3 044 021 005,00	4 682 259 087,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(54 141 062,16)	(118 086 730,20)
39203	Авто тээврийн хэрэгсэл	30 887 609,50	89 155 183,28
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29 999 868,24)	(36 045 470,45)
39205	Машин, тоног төхөөрөмж	1 738 675 190,00	776 514 700,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1 737 397 589,77)	(2 355 200,16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243 754 840,00	227 145 950,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(169 712 992,12)	(162 788 552,44)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	58 845 400,00	36 306 300,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	22 539 100,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(3 756 517,02)
39217	Номын фонд	8 877 990,00	-
393	Биет бус хөрөнгө	45 000,00	910 000,00
39301	Програм хангамж	1 675 000,00	1 210 000,00
39302	Хасагдуулга	(1 630 000,00)	(300 000,00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3 204 294 686,41	5 576 375 781,21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3 204 294 686,41	5 576 375 781,21
51	Засгийн газрын хувь оролцоо	3 204 294 686,41	5 576 375 781,21
512	Хуримтлагдсан үр дүн	3 186 307 730,12	5 558 388 824,92
51210	Өмнөх үеийн үр дүн	3 186 307 730,12	3 186 307 730,12
51220	Тайлант үеийн үр дүн	-	2 372 081 094,80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17 986 956,29	17 986 956,29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3 204 294 686,41	5 576 375 781,21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	789 971 740,71	1 283 356 573,78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3 461 708,71	846 262 873,78
120	Нийтлэг татварын бус орлого	3 461 708,71	846 262 873,78
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3 461 708,71	846 262 873,78
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3 837 600,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3 461 708,71	842 425 273,78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	786 510 032,00	437 093 700,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	335 617 100,00	399 578 700,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	335 617 100,00	399 578 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	450 892 932,00	37 515 000,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	131 121 400,00	17 200 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас	306 009 032,00	20 000 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13 762 500,00	315 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	858 284 986,98	549 513 560,98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	858 284 986,98	549 513 560,98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	844 942 056,37	528 451 285,02
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	237 725 721,26	285 993 626,57
210101	Цалин	196 996 521,26	210 469 000,00
210102	Нэмэгдэл цалин	20 577 500,00	58 372 926,57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20 151 700,00	17 151 700,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29 886 456,10	37 004 234,29
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20 266 700,00	25 563 934,29
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2 384 300,00	2 860 100,00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1 989 956,10	2 288 100,00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	476 800,00	572 000,00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4 768 700,00	5 720 100,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34 052 165,50	32 292 647,35
210301	Гэрэл цахилгааны зардал	18 818 588,00	19 142 462,00
210302	Түлш, халаалтын зардал	10 486 557,50	10 474 345,35
210303	Цэвэр, бохир усны зардал	4 747 020,00	2 675 840,00
2104	Хангамж, бараа материалын зардал	15 206 042,30	23 707 804,83
210401	Бичиг хэргийн материал	4 154 580,00	1 567 060,00
210402	Тээвэр, шатахууны зардал	2 908 100,00	2 316 500,00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	6 469 929,63	5 316 065,83
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1 673 432,67	1 643 881,00
210408	Бараа материал акталсны зардал	-	12 864 298,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6 029 699,00	303 800,00
210601	Багаж хэрэгсэл	114 399,00	-

210604	Урсгал засвар	5 915 300,00	303 800,00
2107	Томилолт, зочны зардал	36 000,00	1 858 000,00
210702	Дотоод томилолтын зардал	36 000,00	1 858 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	165 152 068,00	33 866 634,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163 134 060,00	31 877 200,00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1 500 000,00	1 500 000,00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	483 408,00	171 434,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34 600,00	318 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	356 853 904,21	113 424 537,98
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	273 400 748,00	17 581 500,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83 453 156,21	95 843 037,98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 342 930,61	21 062 275,96
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 000 000,00	10 484 000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	10 484 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1 000 000,00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12 342 930,61	10 578 275,96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1 582 498,61	10 263 275,96
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10 760 432,00	315 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(68 313 246,27)	733 843 012,80
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	1 647 116 072,00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	1 647 116 072,00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	145 185 866,31	8 877 990,00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	145 185 866,31	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	8 877 990,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4=145-225)	(145 185 866,31)	1 638 238 082,00
5	НИЙТ ҮР ДҮН (5=3+4)	(213 499 112,58)	2 372 081 094,80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	786 510 032,00	440 931 300,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3 837 600,00
120	Нийтлэг татварын бус орлого	-	3 837 600,00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	3 837 600,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3 837 600,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	786 510 032,00	437 093 700,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	335 617 100,00	399 578 700,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	335 617 100,00	399 578 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	450 892 932,00	37 515 000,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	131 121 400,00	17 200 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	306 009 032,00	20 000 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13 762 500,00	315 000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	786 510 032,00	438 931 300,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786 510 032,00	438 931 300,00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	773 167 101,39	417 869 024,04
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	237 725 721,26	285 993 626,57
210101	Үндсэн цалин	196 996 521,26	210 469 000,00
210102	Нэмэгдэл	20 577 500,00	58 372 926,57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20 151 700,00	17 151 700,00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	29 803 900,00	37 004 234,29
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20 266 700,00	25 563 934,29
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2 384 300,00	2 860 100,00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1 907 400,00	2 288 100,00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	476 800,00	572 000,00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4 768 700,00	5 720 100,00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	34 052 165,50	32 292 647,35
210301	Гэрэл цахилгааны зардал	18 818 588,00	19 142 462,00
210302	Түлш, халаалтын зардал	10 486 557,50	10 474 345,35
210303	Цэвэр, бохир усны зардал	4 747 020,00	2 675 840,00
2104	Хангамж, бараа материалын зардал	14 960 665,63	10 564 681,83
210401	Бичиг хэрэг	4 293 570,00	1 638 517,00
210402	Тээвэр, шатахуун	2 908 100,00	2 385 500,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6 469 929,63	5 316 065,83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 289 066,00	1 224 599,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6 194 689,00	-
210601	Багаж техник хэрэгсэл	434 389,00	-
210604	Урсгал засвар	5 760 300,00	-
2107	Томилолт, зочны зардал	36 000,00	1 858 000,00
210702	Дотоод албан томилолт	36 000,00	1 858 000,00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165 152 068,00	34 978 334,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	163 134 060,00	32 988 900,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 500 000,00	1 500 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	483 408,00	171 434,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34 600,00	318 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285 241 892,00	15 177 500,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	285 241 892,00	15 177 500,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 342 930,61	21 062 275,96
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 000 000,00	10 484 000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	10 484 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1 000 000,00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12 342 930,61	10 578 275,96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1 582 498,61	10 263 275,96
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10 760 432,00	315 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	2 000 000,00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	2 000 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2 000 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2 000 000,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2 000 000,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(2 000 000,00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/			
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	17 986 956,29	3 399 806 842,70	3 417 793 798,99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(213 499 112,58)	(213 499 112,58)
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	17 986 956,29	3 186 307 730,12	3 204 294 686,41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2 372 081 094,80	2 372 081 094,80
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	17 986 956,29	5 558 388 824,92	5 576 375 781,21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөгөөр/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	399 578 700,00	393 153 024,04	6 425 675,96	98,39
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	399 578 700,00	393 153 024,04	6 425 675,96	98,39
Бараа, үйлчилгээний зардал	389 094 700,00	382 669 024,04	6 425 675,96	98,35
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286 004 600,00	285 993 626,57	10 973,43	100,00
Үндсэн цалин	210 469 000,00	210 469 000,00	-	100,00
Нэмэгдэл	58 383 900,00	58 372 926,57	10 973,43	99,98
Унаа, болон бусад нөхөн олговор	17 151 700,00	17 151 700,00	-	100,00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38 610 800,00	37 004 234,29	1 606 565,71	95,84
Тэтгэврийн даатгал	27 170 500,00	25 563 934,29	1 606 565,71	94,09
Тэтгэмжийн даатгал	2 860 100,00	2 860 100,00	-	100,00
ҮОМШӨ ний даатгал	2 288 100,00	2 288 100,00	-	100,00
Ажилгүйдлийн даатгал	572 000,00	572 000,00	-	100,00
Эрүүл мэндийн даатгал	5 720 100,00	5 720 100,00	-	100,00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36 959 600,00	32 292 647,35	4 666 952,65	87,37
Гэрэл цахилгаан	21 311 800,00	19 142 462,00	2 169 338,00	89,82
Түлш, халаалт	12 105 200,00	10 474 345,35	1 630 854,65	86,53
Цэвэр, бохир ус	3 542 600,00	2 675 840,00	866 760,00	75,53
Хангамж, бараа материалын зардал	10 606 800,00	10 564 681,83	42 118,17	99,60
Бичиг хэрэг	1 639 100,00	1 638 517,00	583,00	99,96
Тээвэр (шатахуун)	2 386 200,00	2 385 500,00	700,00	99,97
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5 355 300,00	5 316 065,83	39 234,17	99,27
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1 226 200,00	1 224 599,00	1 601,00	99,87
Томилолт, зочны зардал	1 874 500,00	1 858 000,00	16 500,00	99,12
Дотоод албан томилолт	1 874 500,00	1 858 000,00	16 500,00	99,12
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7 355 800,00	7 278 334,00	77 466,00	98,95
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5 346 000,00	5 288 900,00	57 100,00	98,93
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1 500 000,00	1 500 000,00	-	100,00
Даатгалын үйлчилгээ	191 800,00	171 434,00	20 366,00	89,38
Тээврийн хэрэгслийн татвар	318 000,00	318 000,00	-	100,00
Бараа үйлчилгээний бусад зардал	7 682 600,00	7 677 500,00	5 100,00	99,93
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7 682 600,00	7 677 500,00	5 100,00	99,93
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10 484 000,00	10 484 000,00	-	100,00
Бусад урсгал шилжүүлэг	10 484 000,00	10 484 000,00	-	100,00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг	10 484 000,00	10 484 000,00	-	100,00

удаагийн мөнгөн тэтгэмж				
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	399 578 700,00	393 153 024,04	6 425 675,96	98,39
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	399 578 700,00	389 315 424,04	10 263 275,96	97,43
Улсын төсвөөс санхүүжих	399 578 700,00	389 315 424,04	10 263 275,96	97,43
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	3 837 600,00	(3 837 600,00)	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3 837 600,00	(3 837 600,00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	-	100,00
Удирдах ажилтан	1	1	-	100,00
Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100,00
Үйлчлэх ажилтан	5	5	-	100,00

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	37 200 000,00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	37 200 000,00
Бараа, үйлчилгээний зардал	-	37 200 000,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	29 700 000,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	29 700 000,00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	7 500 000,00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7 500 000,00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	37 515 000,00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	37 515 000,00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	17 200 000,00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	20 000 000,00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	315 000,00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус төвийн Захирлын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч У.Даваажав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 11-нээс 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Нью Эстимэйтор аудит ХХК-ийн Захирал Т.Бүжидмаа, аудитор Ж.Үхэртар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв нь олон улсын жишигт нийцсэн орчин үеийн технологи, багаж, тоног төхөөрөмж, мэргэшсэн боловсон хүчний нөөцөд тулгуурлан цэнгэг усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, түүнтэй холбоотой байгаль орчныг хамгаалах, сорилт шинжилгээ хийж, усны чанар, төлөв байдлын талаар ашиглагч, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа, судалгааны ажил явуулах, мэргэжлийн болон хөндлөнгийн дүгнэлт гаргах, ус, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагыг усны талаарх мэдээллээр хангах, өсвөр залуу үе, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчин, цэнгэг усны чиглэлээр сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээний ажил явуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тус төвийн тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгээгүй байна.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 250,809.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,016.2 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,372,081.1 мянган төгрөгөөр буюу 74.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	70,439.2	64,577.9	(5,861.3)
Үндсэн хөрөнгө	3,133,855.5	5,511,797.9	2,377,942.4
Нийт хөрөнгө	3,204,294.7	5,576,375.8	2,372,081.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,204,294.7	5,576,375.8	2,372,081.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,204,294.7	5,576,375.8	2,372,081.1

Бараа материалын дансны үлдэгдэл 64,577.9 мянган төгрөг болж 5,861.3 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтгүй бараа материалыг данснаас хассанаас шалтгаалжээ.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэх худалдан авалт хийгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,511,797.9 мянган төгрөг болж 2,377,972.4 мянган төгрөгөөр өссөн нь барилгын дахин үнэлгээ хийсэн мөн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосноос шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 2,000.0 мянган төгрөг, хандиваар шилжиж ирсэн 56,267.6 мянган төгрөг, дахин үнэлгээ хийгдсэн 1,638,238.1 мянган төгрөг, үнийг шинэчлэн тогтоосон 786,157.7 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө нь бараа материалын дансанд шилжүүлсэн 8,877.9 мянган төгрөг, акталсан 181,757.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,576,375.8 мянган төгрөг болж 2,372,081.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Тус төв нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын дагуу барилгыг дахин үнэлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнийг шинэчилж бүртгэсэнтэй холбоотой хөрөнгө, өмчийн данс өмнөх оноос өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 493,384.8 мянган төгрөгөөр буюу 62.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон үйл ажиллагааны бус орлого байна. Энэ нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосноос мөн хөрөнгийн дахин үнэлгээний олз үүссэнээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 308,771.4 мянган төгрөгөөр буюу 35.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа ажил үйлчилгээний зардал болон үйл ажиллагааны бус зардлууд байна. Энэ нь 2019 онд нэмэлт санхүүжилтийн дансаар 450,892.9 мянган төгрөгийн орлого орж түүнтэй холбоотой зардлууд гарсан бөгөөд тайлант онд 37,515.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого орсонтой холбоотойгоор зардал буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 501,561.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 95,706.8 мянган төгрөгөөр бууруулж 405,854.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөл нь өмнөх оны баталсан төсвөөс 70,237.6 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь тэтгэвэрт гарах ажилтны нэг удаагийн тэтгэмж, төрийн албан хаагчийн цалингийн өсөлт болон нийгмийн даатгалын шимтгэлийн өсөлтөөс шалтгаалсан байна. 2020 оны 9 дүгээр сард тус төвийн төсөвт 6,276.2 мянган төгрөгөөр тодотгол хийж батлагдсан төсөв 399,578.7 мянган төгрөг болсон байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 399,578.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 3,837.6 мянган төгрөг, нийт 403,416.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 393,153.0 мянган төгрөгийг зарцуулж 10,263.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 393,153.0 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь ашиглалтын зардлыг 4,666.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,606.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 17,200.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 20,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 315.0 мянга, нийт 37,515.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс “Ус ба уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт цахим илтгэл бэлтгэхэд 5,000.0 мянга, Усны зохистой ашиглалт, хэрэглээ болон тогтвортой хөгжил сэдвээр видео контент бэлтгэх болон Иргэд олон нийтэд Тогтвортой хөгжлийн үзэл санаа, ногоон хөгжлийн үзэл баримтлалыг ойлгуулах байгаль орчны талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтын модуль боловсруулах ажлуудын зардалд 15,000.0 мянга, “Та өөрийгөө агаарын бохирдлоос хамгаалж чадна” эсээ бичлэгийн уралдааны зардалд 17,200.0 мянга, нийт 37,200.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 315.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого байхгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,849.1 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмжийн 1 зөвлөмжийг биелүүлж 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 50.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-					
Албан шаардлага	-	-					
Зөвлөмж	2	2,849.1	1	2,849.1	1	-	50.0
Нийт дүн	2	2,849.1	1	2,849.1	1	-	50.0

Хэрэгжүүлээгүй шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мөн иж бүрэн оруулахтай холбоотой 1 зөвлөмжид албан шаардлага тогтоов.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илэрсэн бөгөөд тус зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч уг зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь байршуулах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой гэрээ дүгнэсэн актыг бүрэн байршуулаагүй 5 гүйлгээ, мөн 10,484.0 мянган төгрөгийн тэтгэвэрт гарсан ажилтны нэг удаагийн тэтгэмжийн зарлагын 1 мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 7 мэдээний шийдвэрийн хуулбарыг бүрэн байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх болон анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.19			САГ-2021/39/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй байна.	10,484.0	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	О.Баярцэцэг
	ДҮН	10,484.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 57/АД/20078

Улаанбаатар хот

СЯТ-2021/39/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээг байршуулаагүй байна. Мөнгөн гүйлгээтэй холбоотой гэрээ дүгнэсэн актыг бүрэн байршуулаагүй 5, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 7, нийт 12 мэдээний шийдвэрийн хуулбарыг бүрэн байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Даваажав, нягтлан бодогч О.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
НЬУ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Ж.ҮХЭРТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.20.Бичиг_Хярег_Албан_Шаардлага_2021/0225_Аудитын_2-Р_Газар35_Docx

001081137

